



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/697

Булган сум

**Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх  
тусгай зөвшөөрлийн тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2.2.1, 8.1 дүгээр зүйлийн 2 дугаар хэсгийн 12.13, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан "Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл"-ийг шинээр олгох цэгийн нэрсийг хавсралтаар баталж, 5 жилийн хугацаатай олгосугай.

2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2-т заасан тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга нар, Татварын газар (Д.Лхагвасүрэн), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т тус тус даалгасугай.

3. Дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Г.Ганбаяр цагдаагийн дэд хурандаа), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан), Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Ц.Бүрэнтуяа), сумын Засаг дарга, аж ахуйн нэгж байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
10 дугаар сарын 22 ны/ний өдрийн 4/697 дугаар  
захирамжийн хавсралт



**“СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ” ЭЗЭМШИХ ЦЭГИЙН НЭРС**

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл	Бар, ресторан, дэлгүүрийн нэр
1	2	3	4	5	6
1	Баяннуур	“Буман тэмээт” ХХК	Б.Баяндалай	Хүнсний дэлгүүр	“Мини маркет”
2	Гурванбулаг	“Оч мэргэн” ХХК	Х.Алтанцэцэг	Хүнсний дэлгүүр	“Оч мэргэн”
3	Булган	“Хийморлог хөвгүүд” ХХК	Д.Ганхуяг	Хүнсний дэлгүүр	“Арвижах”
4	Булган	“Премиум нэксус” ХХК	Г.Чинзориг	Хүнсний дэлгүүр	“Си юу-1”
5	Дашинчилэн	“Цойлох” ХХК	А.Даваасүрэн	Хүнсний дэлгүүр	“Дэлгэрэх ”
6	Дашинчилэн	“Аз завьяа” ХХК	Д.Ариун-Од	Хүнсний дэлгүүр	“Нарру” “Мини маркет”
7	Рашаант	“Ханги бэйл” ХХК	О.Найдан	Хүнсний дэлгүүр	“Ханги бэйл”
8	Сайхан	“Их бүтээл Ундарга” ХХК	Г.Хайдавваанчиг	Баар	“Ундрах”
9		Насан дэлгэрэх трейд ХХ	Ч.Оюун-Эрдэнэ	Хүнсний дэлгүүр	“Насан дэлгэрэх”
10	Хутаг-Өндөр	“Баатар ван тур” ХХК	Д.Баттөр	Баар	“Ривер лоунж”
11				Ресторан	“Баатарван”
	Нийт-12				